

**ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРААС 2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**


Нэг: Дотоод хяналт шалгалтын чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Завхан, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Мэдээлэл, холбоо технологийн төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар, Цагдаагийн ерөнхий газрын Холбооны хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газар, Тусгай ажиллагааны газарт аудитын, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс аймаг дахь цагдаагийн газар, хэлтэс, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын 805 дугаар анги, Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын алба хаагчдын үйл ажиллагаанд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу нийт 15 удаагийн шалгалтыг явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр хугацаатай үүрэг, зөвлөмж хүргүүлж, ажлын байрны зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн, цагдаагийн алба хаагчийн ёс зүйг зөрчсөн алба хаагчид Төрийн албаны тухай хуулиар сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Санхүүгийн болон дотоод аудитын чиглэлээр Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, төсөв, хөрөнгийн төлөвлөлт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын байдалд шалгалт хийхэд 85 929.4 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн.

Зөрчил дутагдлыг эзлэх хувийн жингээр авч үзвэл:


Д/д	Төлбөр, зөрчлийн нэр	Мөнгөн дүн	Эзлэх хувь
1	Орлого	464.6	0.54
2	Татвар, НДШ	2,554.00	2.97
3	Үнэт цаас	3,124.00	3.64
4	Хувцас	16,563.50	19.28
5	НББ-тэй холбоотой	29,280.30	34.07
6	Цалин	33,943.00	39.50
	Нийт дүн	85,929.40	100.00



Хоёр: Өргөдөл, гомдол, мэдээллийн талаар

2014 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 365 гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч 332 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн бөгөөд 33 гомдол, мэдээлэлд шалгалтын ажиллагааг явуулж байна.


Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийг урьд оны мөн үетэй харьцуулахад 109 буюу 42,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.





Хүлээн авсан гомдол, мэдээллийг зөрчлийн төрлөөр нь авч үзвэл:



Дээрх гомдол, мэдээлэлд 388 цагдаагийн алба хаагч холбогдон шалгагдсанаас 337 нь офицер, 51 нь ахлагч байна.



Сэлэнгэ болон Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчидтай холбоотой 7-9 гомдол, мэдээлэл, Нийслэлийн Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Нийслэлийн замын цагдаагийн алба хаагчидтай холбоотой 31-33 гомдол, мэдээлэл ирсэн нь бусад нэгжүүдээсээ олон байна.



Ирсэн гомдол, мэдээллийн дагуу албаны шалгалт явуулж, буруутай үйлдэл тогтоогдсон 84 алба хаагчид сахилгын арга хэмжээ тооцуулж, 16 алба хаагчид холбогдох гомдол, мэдээллийг харьяаллын дагуу эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар шилжүүлжээ.

Гурав: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдлийг тодорхойлж, үнэлгээний тайланг гаргаж, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдлийн удирдлагын журам”-ыг шинээр боловсруулж батлуулав.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон Цагдаагийн байгууллагын 2013 оны үйл ажиллагаа, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” хууль болон “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, сурталчлах журам”-ын хэрэгжилтэд тус тус хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмжийг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад хүргүүллээ.

Дөрөв: Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө, Авлигаас урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөл, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг бүртгэх, хадгалах, хяналт тавих эрх бүхий албан тушаалтнуудыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргуулж авах ажлыг зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудаас санаачлан

“Авлига үгүй гэж хэлэх ёс зүйтэй

Авлигаас ангид амьдрах орчин нөхцөлтэй

Төрийн байгууллагуудыг авлигагүйгээр манлайлж

Том төрөөс ухаалга төрийн санаачлагыг хэрэгжүүлж

Авлигагүй нийгмийг сонгон амьдрахыг” цагдаагийн байгууллагын нийт алба алба хаагчдад уриалга гарган ажиллаж байна.


Мөн Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Дотоод хяналт аюулгүй байдлын газрын дарга, дэд комиссар Д.Эрдэнэбаатар Цагдаагийн байгууллагаас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын талаар өдөр дутмын “Үндэсний шуудан” сонинд ярилцлага өглөө.

Орхон, Булган, Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хадгалалт хамгаалалтыг шалган зааварчилж, цагдаагийн байгууллагад шинээр болон албан тушаал дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 374 алба хаагчийн урьдчилсан мэдүүлгийг дүгнэлт гаргуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.



Тус газраас Авлигын эсрэг хуульд заасан эрх хэмжээний дагуу цагдаагийн байгууллагын хэмжээнд тасгийн даргаас дээш албан тушаалд ажиллаж байгаа 800 алба хаагч, түүний гэр бүлийн 750, нийт 1550 хүний хөрөнгө, орлогын мэдүүлэгт шалгалтын

ажиллагааг явуулж, зөрчлийг засуулах ажлыг зохион байгууллаа. Шалгалтын ажиллагаанд цагдаагийн байгууллагын алба хаагчдын 12 хувийн хамруулсан байна.



Цагдаагийн байгууллагын алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд суртлын талаар мэдээлэл хүлээн авах 126 тусгай дугаарын утсыг иргэд, олон нийтэд таниулан сурталчилах чиглэлээр “126 дугаарын утас”-ны зурагт хуудасны уралдааныг Шинжлэх ухаан техникийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологи Дизайны сургууль, Үндэсний гэрэл зургийн танхимтай хамтран зохион байгуулсан.



Үүний үр дүнд Шинжлэх ухаан техникийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологи, Дизайны сургууль, Үндэсний гэрэл зургийн танхимтай хамтран цагдаагийн байгууллагын алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд суртлын талаар мэдээлэл хүлээн авах 126 тусгай дугаарын утсыг иргэд, олон нийтэд таниулан сурталчиллаа.

Оюутан залуусын бүтээлч ажиллагааг дэмжих, уран бүтээлийг нь бусдад сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тус сургуулийн оюутнуудын дунд зурагт хуудасны уралдааныг зохион байгуулж, Үндэсний түүхийн музейд үзэсгэлэн гаргасан.



Алба хаагчдад Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

хууль тогтоомжийг таниулах, аливаа хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой нийтлэл, илтгэлийн зохион байгууллаа.

Шалгаруулалтад тэргүүн байрыг Орхон аймаг дахь цагдаагийн газрын эдийн засгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч Д.Гантөмөрийн “Хүмүүн заяаны үнэ цэнийг өлмийдөө гишгэсэн авлига”, дэд байранд Хөвсгөл аймгийн цагдаагийн газрын эрэлч нохойн туслах төлөөлөгч, цагдаагийн ахлах ахлагч А.Дашцоожийн “Цаасан хараал”, гутгаар байранд Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын сэтгэл зүйч М.Одонгоогийн “Тэр бидэнд хэрэггүй” бүтээл тус тус шалгарлаа.

Цагдаагийн ерөнхий газрын Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний дагуу 2014 оны 06 дугаар сарын 17-27- ны өдөр Монголын Сурагчдын холбоотой хамтран “Авлигал хүүхдийн нүдээр” гар зургийн уралдаан зохион байгуулж дүгнэлээ.



Уралдаанд Монгол Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Өсвөрийн 333 сурагч” аяны шилдэг 66 сурагчийн 71 бүтээл ирснээс Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р сургуулийн сурагч Б.Отгончимэгийн цуврал зургууд тэргүүн байр, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын 5-р сургуулийн сурагч Э.Ану-Үжин, Нийслэлийн 6-р сургуулийн 6в ангийн сурагч Ц.Жавхлан нар удаах байруудыг эзэллээ.

Тав: Бусад ажлын талаар

Харьяа нэгжийн удирдах албан тушаалтан, алба хаагч нарт “Хяналт-шинжилгээ /Мониторинг/ хийх аргачлал”, “Дотоод аудит”, Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигаас урьдчилан сэргийлэх болон ХАСХОМ-ын бүрдүүлэлтийн талаарх сургалтыг тус тус зохион байгуулав.



“Цагдаагийн алба хаагчийн ёс зүй” сэдвээр Дотоодын цэргийн 1028 алба хаагчид 30 цагийн, “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах арга зүй” сэдвээр 20 алба хаагчид 8 цагийн, Хуул сахиулахын их сургуулийг 2014 онд төгссөн 20 алба хаагчид “Онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх” сэдвээр нийт 42 цагийн хичээлийг газрын алба хаагчдаас заасан.

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗАР